

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 2007 ОНЫ ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

1.Макро эдийн засаг

Төсөв санхүү

Аймгийн төсөвт 3344.3 сая. төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 116.9 хувиар биелж, хүн амын орлогын албан татвар 50.0 хувиар, өмчийн татвар 43.7 хувиар, тусгай зориулалтын орлого 22.0 хувиар, бусад татварын орлогын төлөвлөгөө 2.9 хувиар давж биелэжээ. Өнгөрсөн оноос орон нутгийн төсвийн орлого 2.4 дахин нэмэгдсэн байна.Нийт төсвийн орлогын 12.0 хувь буюу 402.4 сая.төгрөг нь нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татварын шилжүүлгийн орлого байна.

Орон нутгийн төсвөөс 17858.8 сая. төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 9.3 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 42.9 хувийг цалин хөлсөнд, 37.5 хувийг бараа үйлчилгээний зардалд, 6.2 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ. Салбарын хувьд нийтийн ерөнхий үйлчилгээнд 19.8 хувийг,НХЖА байдлын үйлчилгээнд 5.2 хувийг боловсролд 42.7 хувийг, эрүүл мэндийн үйлчилгээнд 20.5 хувийг,бусад салбаруудад 11.8 хувийг тус тус зарцуулсан байна. Улсын төсвөөс 13.4 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсэн ба өнгөрсөн оноос 38.1 хувиар нэмэгджээ.

Төсвийн байгууллагуудын дүнгээр 3.1 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Өр үүсээгүй байна.

Дундаж цалин орлого

Дундаж цалин орлогын судалгаанд Дэлгэрэх хүнс,Онги-Ус суваг,АЗ-ЗА ӨВ,ӨВ Илч,ДУК,Баянтээг,Арцатбогд трейд, Сант мандах,НДХэлтэс,БСГазар,ЭМГазар, ХДТеатр зэрэг 41 байгууллагын 3565 ажиллагсад хамрагдсанаас 59.1 хувийг төрийн болон төсөвт байгууллага, 13.4 хувийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, 27.5 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн ажиллагсад эзэлж байна. 2007 онд судалгаагаар нэг ажилтны сарын дундаж цалин, орлого 131200 төгрөг, үүнээс үндсэн цалин 119300 төгрөг байна.

Ажил эрхлэлт ба ажилгүйдэл

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 67083 хүн байгаагаас 49410 ажиллагсад, ХЭАлбанд бүртгэлтэй ажилгүйчүүд 2147, бүртгэлгүй ажил эрхлээгүй хүн ам 5685, суралцагсад 6397, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам 3448 байна.Нийт ажиллагсадын 64.7 хувь нь ХАА-н салбарт ажиллагсад эзэлж байна.Ажиллагсадын тоо өмнөх оныхоос 3.8 хувиар өссөн байна.

Жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст 2147 хүн бүртгэлтэй байгаагийн 57.3 хувь нь эмэгтэйчүүд байна.Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 32.8 хувь нь 25-34 насныхан, 27.2 хувь нь 35-44 насныхан, 28.7 хувь нь 16-24 насныхан, 11.3 хувь нь 45-60 насныхан байгаа ба 51.1 хувь нь урьд нь ажил эрхэлж байсан, 48.9 хувь нь анх удаа ажил эрж байгаа хүмүүс байна. Бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 0.2 хувь нь орон тооноор цомхтголоор ажлаас гарсан, 0.5 хувь нь ямар нэгэн шатны сургууль төгсөөд ажилгүй байна.Ажилгүйдлийн түвшин бүртгэлтэй ажилгүйчүүдээр авч үзвэл 4.7 хувь, бүртгэлгүй ажилгүйчүүдээр тооцвол 11.0 хувь байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 35.0 хувь нь бүрэн дунд, 12.0 хувь нь дээд, 31.7 хувь нь бүрэн бус дунд, 4.7 хувь нь тусгай дунд, 9.7 хувь нь мэргэжлийн анхан шатны, 5.9 хувь нь бага боловсролтой байна.

Тайлант онд аймгийн хэмжээнд 2147 ажлын байр шинээр бий болж өмнөх оноос 56.1 хувиар нэмэгджээ.Үүний 1806 нь байнгын,341 нь түр ажлын байр байна.

Ажлын байраар хангагдагсдын 15.7 хувь нь барилгад, 15.6 хувь нь хөдөө аж ахуйд,12.6 хувь нь үйлдвэрлэлд, 4.3 хувь нь зочид буудал зоогийн газарт,20.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаанд , 5.8 хувь нь тээвэр, холбоонд,6.6 хувь нь уул уурхайд, 18.7

төсөвт байгууллага болон хувийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд ажлын байртай болжээ.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс өмнөх оныхоос 22.4 хувиар нэмэгдэж, сарын индекс өмнөх 11-р сараас 0.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны 12-р сартай энэ оныг харьцуулахад хүнсний барааны бүлгийн индекс 30.9 хувиар, гутал бөс бараанд 8.7 хувиар, орон сууцанд 19.8 хувиар, гэр ахуйн бараанд 28.8 хувиар, эм тариа эмнэлгийн үйлчилгээнд 15.0 хувиар, тээвэр холбоонд 32.0 хувиар, соёл боловсролын үйлчилгээнд 15.1 хувиар, бусад бараанд 17.3 хувиар нэмэгдсэн байна.

Банк, мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 10.8 тэрбум төгрөгийг гүйлгээнээс татаж, 38.5 тэрбум төгрөгийг гүйлгээнд гаргасан байна. Өнгөрсөн оноос гүйлгээнээс татсан төгрөгийн хэмжээ 22.7 хувиар багасч, гүйлгээнд гаргасан төгрөгийн хэмжээ 31.4 хувиар нэмэгджээ.

Иргэд, байгууллагын мөнгөн хадгаламж 7.8 тэрбум төгрөг болж аймгийн нэг хүнд дунджаар 71600 төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 250200 төгрөгийн хадгаламж ногдож байна. Өнгөрсөн оноос хадгаламжийн үлдэгдэл 77.6 хувиар, хадгаламж эзэмшигчийн тоо 2.1 дахин өсчээ.

Арилжааны банкуудын дүнгээр 25737 иргэд, аж ахуйн нэгжид 27.5 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оноос зээлжигч 21.2 хувиар, олгосон зээлийн хэмжээ 74.0 хувиар нэмэгджээ.

Банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн сарын хүү 0.5-0.8 хувь, хугацаатай хадгаламжийн хүү 0.8-1.55 хувьтай байна.

2. Нийгмийн үзүүлэлт

Хүн ам

Оны эцэст аймгийн нийт хүн ам 109.5 мянга, өрх 29.7 мянгад хүрч, өнгөрсөн оноос хүн амын тоо 0.5 хувиар багасч, өрхийн тоо 1.7 хувиар нэмэгджээ. Нийт хүн амын 32.4 хувийг 0-15 насны хүүхэд, 60.8 хувийг 15-59 насны, 6.8 хувийг 60 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна. 100 ба түүнээс дээш настай хүн 4 байна.

Аймгийн нийт өрхийн 44.0 хувь, нийт хүн амын 47.1 хувь нь сумын төвүүдэд суурьшсан байна.

Хүн амын ердийн хөдөлгөөн

Төрсөн 2387 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 618 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 1401 гэрлэлтийг бүртгэн, 12 гэрлэлтийг цуцалж, 94 хүүхэд үрчлэгдсэн байна.

Бүртгүүлсэн гэр бүлийн 57.2 хувь тайлант онд гэрлэжээ. Гэрлэсэн эрэгтэйчүүдийн 30.8 хувь нь 20-24 насныхан, 40.2 хувь нь 25-29 насныхан, эмэгтэйчүүдийн 40.5 хувь нь 20-24 насныхан байна.

Нийт гэр бүл цуцлалтын 50.0 хувь 4-6 жил гэр бүл байсан, үрчлэлтийн 35.1 хувь 3 хүртэл насны хүүхэд байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөн

Тайлант жилд Улаанбаатар болон бусад аймгуудад 2103 хүн шилжин явж, тэдгээрээс 575 хүн шилжин иржээ. Шилжин явагсдын 82.7 хувь нь Улаанбаатар хот руу шилжин явсны 55.9 хувь нь 15-54 насныхан байна.

Сүүлийн 2 жилд шилжин ирэгсдээсээ шилжин явсан хүний тоо их байгаа бөгөөд шилжих хөдөлгөөн 1.7х1 харьцаатай байна.

Хүн амын эмзэг бүлэг

Сумдуудын өөрсдийнх нь тодорхойлж ирүүлсэн мэдээгээр амьжиргааны баталгаажих доод төвшнөөс доогуур орлоготой 5813 өрхөд 22.6 мянган хүн амьдарч байгаа нь нийт өрхийн 20.7, нийт хүн амын 19.5 хувь байна.

Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой өрхийн 23.3 хувь нь нэн ядуу өрх байна. Амьжиргааны баталгаажих доод түвшин бүсийн хэмжээнд сард нэг хүнд 54600 байгаа юм.

Аймгийн хэмжээнд 201 бүтэн өнчин, 1965 хагас өнчин хүүхэд, хүүхэдтэй гэр бүлгүй хүн 2121, өрх толгойлсон эмэгтэйчүүд 2681 байна. Нийт өрхийн 9.0 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.

Нийгмийн халамж, даатгал

Аймгийн дүнгээр 74454 хүнд 5.6 тэрбум төгрөгийн халамж асрамжийн үйлчилгээ үзүүлжээ. Нийт 2188 хүнд 608.3 сая.төгрөгийн халамжийн тэтгэвэр, 44548 хүүхдэд 1533.2 сая.төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид, шинээр төрсөн 2578 хүүхдэд 257.8 сая.төгрөгийн тэтгэмж, шинээр гэр бүл болсон 3378 өрхөд 1689.0 сая.төгрөгийн тэтгэмж, алдарт эхийн одонтой 1966 эхчүүдэд 196.6 сая.төгрөгийн тэтгэмж, 5848 ахмад настанд 162.6 сая.төгрөгийн, хөгжлийн бэрхшээлтэй 2631 хүнд 98.5 сая.төгрөгийн хөнгөлөлтийг олгожээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 11.1 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 103.3 хувиар биелэн өнгөрсөн оноос сангийн нийт орлого 32.1 хувиар нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сайн дурын орлого 124.7 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 103.6 хувь, эрүүл мэндийн даатгалын хураамж 118.9 хувь, тус тус биелжээ. Бүх төрлийн тэтгэвэр авагч 12950 хүнд 9.4 тэр.бум төгрөгийн тэтгэвэр 1620 хүнд 160.1 сая.төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Өрхийн амьжиргааг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа “Тогтвортой амьжиргаа” төслөөс аймгийн хэмжээнд 2007 онд 163.9 сая төгрөгийн 43 төслийг хэрэгжүүлсэн байна. Үүнд: Боловсролын салбарт 110.5 сая.төгрөгийн 31 төсөл, эрүүл мэндийн салбарт 33.6 сая.төгрөгийн 9 төсөл хэрэгжүүлж сум орон нутагт тулгамдсан асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэсэн байна.

Боловсрол

2007-2008 оны хичээлийн жилд 28 сургуулийн 723 бүлэгт 24.3 мянган хүүхэд суралцаж, 30 цэцэрлэгт 3.3 мянган хүүхэд хүмүүжиж, эдгээрт 956 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байгаа нь өнгөрсөн оноос суралцагсад 0.8 хувиар нэмэгдэж, цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхэд 3.9 хувиар буурч, багш сурган хүмүүжүүлэгч 2.9 хувиар буурсан байна.

Нэг ангид ногдох хүүхдийн тоо 34.0 байгаа нь өмнөх хичээлийн жилийнхээс 0.5 пунктээр нэмэгдсэн байна.

2006-2007 оны хичээлийн жилд 3920 хүүхэд 8, 10-р ангийг төгссөнөөс 57.4 хувь нь суурь боловсролыг, 42.5 хувь нь бүрэн дунд боловсролыг эзэмшсэн байна. Төгсөгчдийн тоо өмнөх хичээлийн жилээс 9.8 хувиар нэмэгджээ.

Аймгийн 2 Их сургуульд 711 оюутан, 905 сурагч суралцаж байна.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2424 эх амаржин, 600 хүн нас барж өнгөрсөн оноос төрөлт 12.9 хувиар нэмэгдэж, нас баралт 3.1 хувиар буурсан байна. Нас баралтын 11.5 хувийг нялхсын нас баралт эзэлж байгаа ба энэ нь өнгөрсөн оноос 38.0 хувиар ихэссэн байна. 1000 хүнд ногдох төрөлт 0.2 промилээр нэмэгдэж, нас баралт 0.2 промилээр буурчээ. Төрөхийн улмаас 3 эх эндсэн байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн 1986 тохиолдол гарсан нь өнгөрсөн оноос 24.3 хувиар өссөн байна. Нийт өвчлөлтийн 24.6 хувийг халдварт шар, 4.1 хувийг сүрьеэ, 6.1 хувийг цусан суулга, 7.8 хувийг заг хүйтнээр, 9.1 хувийг салхин цэцэгээр, 38.1 хувийг краснухаар өвчлөгсөд эзэлж байна.

Соёл урлаг

Номын сан 65.2 мянган ширхэг хөмрөгийн номтой ба 11.2 мянган хүнд 36.2 мянган ширхэг олгон уншуулж үйлчилжээ. 2007 онд 1850.0мян.төгрөгийн 400 номоор номын фондоо баяжуулсан байна.

Музейн 4015 үзмэрээс онцгой үзмэр 15 буюу 0.4 хувийг эзэлж байна. Үзмэрээс 502.0 мян.төгрөгийн орлого олж өнгөрсөн оноос 18.0 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн ХДТеатр 12 удаа тоглолт хийн, 5640 хүнд тоглолтоо толилуулан, 2255.5 мян. төгрөгийн орлоготой ажиллажээ.

Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 545 хэрэг бүртгэгдэж, 561 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 88.8 хувьтай байна. Өнгөрсөн оноос хэргийн илрүүлэлт 2.1 пунктээр буурч, гарсан хэрэг 9.2 хувиар өссөн байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 1.2 хувь нь хүнд, онц хүнд хэрэг, 34.8 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 19.0 хувь нь бүлэглэн үйлдэгдсэн хэрэг байгаа ба өнгөрсөн онтой харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 7.3 хувиар өсч, хүнд, онц хүнд хэрэг 58.9 хувиар буурч, бүлэглэн үйлдсэн хэрэг 28.4 хувиар өссөн байна..

Бүртгэгдсэн хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл нийт хэргийн 39.6 хувийг хулгайн хэрэг, 28.0 хувийг иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг, 8.0 хувийг танхай, 2.2 хувийг дээрмийн хэрэг, 7.5 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг, 0.9 хувийг хүчингийн хэрэг, 1.2 хувийг хүн амины хэрэг, 1.8 хувийг ашиглан шамшигдуулах хэрэг, 1.1 хувийг албан тушаалын хэрэг эзэлж байна.

Өнгөрсөн оноос хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг 17.1 хувиар, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 42.9 хувиар, булаалт дээрмийн 20.0 хувиар, залилан дээрмийн хэрэг 25.0 хувиар, иргэдийн орон байрны хулгай 33.8 хувиар өсч, иргэдийн малын хулгай 38.2 хувиар буурч, бусад хэргийн гаралт 55.0 хувиар нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 360.9 сая төгрөгийн хохирол учирч, 90 хүн нас барж, 224 хүн хүнд хөнгөнөөр гэмтсэн ба нийт хохирлын 51.2 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон 524 хүний 35.8 хувь нь эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 28.7 хувь нь бүлэглэн, 36.3 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн ба 8.2 хувь нь 17 хүртэл насны хүмүүс байна.

Хэв журмын нөхцөл байдлын хувьд 2923 мянган хүн эрүүлжигдэн, 260 хүн захиргааны шийтгэлээр баривчлагдаж, хутга мэстэй холбоотой 258 зөрчил гарч, өнгөрсөн оноос эрүүлжүүлэгдсэн хүний тоо 11.0 хувиар өсч, хутга мэстэй холбоотой зөрчил 7.6 хувиар, баривчлагдсан хүний тоо 72.2 хувиар нэмэгдсэн байна.

Нийт 1592 тээврийн хэрэгслэлийг журамлаж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 143 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ.

3.Үйлдвэрлэл үйлчилгээний салбар.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 2625.0 сая. төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, оны үнээр 2619.2 төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос үйлдвэрлэлт 29.5 хувиар, борлуулалт 30.8 хувиар өссөн байна. Нийт бүтээгдэхүүний 38.6 хувийг хүнсний салбарт, 14.7 хувийг цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт, 18.2 хувийг мод модон эдлэлийн үйлдвэрлэл 17.0 хувийг уул уурхайн салбарт, 11.5 хувийг бусад жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлийн салбаруудад тус тус үйлдвэрлэжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад хэвлэл үйлдвэрлэлт 39.5 хувиар буурч, бусад салбарын үйлдвэрлэлт 0.2-3.5 дахин хувиар өссөн байна.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 71.3 хувийг талх, нарийн боов үйлдвэрлэлт, 25.2 хувийг архи үйлдвэрлэлт, 3.5 хувийг ундаа үйлдвэрлэлт эзэлж байна.

Хөдөө аж ахуй

Жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогоор 3190.1 мянган мал тоологдож оны эхний малын 99.5 хувь онд орсон нь өнгөрсөн оноос 0.5 пунктээр нэмэгдсэн байна. Малын тоо толгой өнгөрсөн оноос 566.9 мянган толгойгоор буюу 21.6 хувиар 5 төрлөөрөө өсчээ.

Аймгийн дүнгээр тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа 4.0-23.9 хувиар өссөн байна. Малын тоо толгой бүх сумдад өссөнөөс Уянга, Хайрхандулаан, Батэлзий 3-аас бусад бүх сумд 5 төрлөөр нь өсгөсөн байна.

Бэлэн малын 99.8 хувь нь амины, бусад нь албан газрын мал бөгөөд нийт малын 44.1 хувийг ямаа, 45.8 хувийг хонь, 4.2 хувийг үхэр, 5.5 хувийг адуу, 0.4 хувийг тэмээ эзэлж, 10.5 хувь нь бод мал байна.

Аймгийн дүнгээр 19964 малтай өрх, үүнээс 16575 нь малчин өрх байна. Эдгээр өрхийн тоо 2006 оныхоос малтай өрх 3.2 хувиар, малчин өрх 0.4 хувиар буурсан байна. Аймгийн нэг малтай өрхөд 160, нэг малчин өрхөд 192 толгой мал ноогдож байна.

Аймгийн хэмжээнд 1000 ба түүнээс дээш малтай 164 өрх байгаа нь өмнөх оныхоос 1.9 дахин нэмэгдсэн байна.

Оны эхний малын 140.5 мянган малыг зах зээлд худалдан борлуулж, 265.7 мянган малыг хүнсэнд хэрэглэж, 152.9 мянгыг бусдад шилжүүлсэн байна.

1251.8 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 39.1 хувийг эзэлж, өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 19.6 хувиар буюу 204.9 толгойгоор өсч нийт малд эзлэх хувийн жин 6.7 пунктээр өссөн байна.

37128 толгой хээлтүүлэгчийн 74.7 хувийг хуц, ухна эзэлж байна. Нэг хээлтүүлэгчид 20 ингэ, 7 гүү, 19 үнээ, 42 эм хонь, 41 эм ямаа ногдож байгаа нь үржлийн нормт хэмжээнээс ингэ, гүү доогуур, эм хонь, эм ямаа нормын түвшинд байна.

Аймгийн хэмжээнд аж ахуй нэгж байгууллагууд 7411 толгой мал тоолуулсан байна. Цэвэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 218.8 мян. мал тоологдсоны 7.5 хувь буюу 16211 нь цэвэр үүлдэр, 92.5 хувь буюу 202621 нь эрлийз үүлдрийн мал байна.

Аймгийн дүнгээр 126 гахай, 3 илжиг, 875 тахиа тоологдож, өмнөх оноос гахайн тоо 13.5 хувиар нэмэгдэж, тахиа 7.2 хувиар буурчээ.

Оны эхний төллөх эх малын 95.3 хувь буюу 997.4 мянган эх мал төллөж гарсан төлийн 98.2 хувь буюу 983.7 мянган төлийг бойжуулсан байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад төллөсөн хээлтэгч 17.8 хувиар, бойжуулсан төл 20.6 хувиар тус тус дээгүүр байна.

Оны эхний нийт малын 0.4 хувь буюу 12050 толгой мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оноос 37.3 хувиар бага байна. Нийт хорогдлын 82.5 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 22.9 хувь буюу 2755 нь өвчнөөр хорогдсон байна.

Аймгийн хэмжээнд энэ онд шинээр 102 худаг гаргаж, 78 худаг засварласан байна.

Аймгийн дүнгээр хаврын тариалалтаар 1145.0 га-д үр тариа, 219.2 га-д төмс, 116.7 га-д хүнсний ногоо тариалж, намрын ургац хураалтаар 50 га-аас 4.4 тн үр тариа, 222.2 га-аас 2025 тн төмс, 115.1 га-аас 1281.8 тн хүнсний ногоо хураан авчээ. Өнгөрсөн оноос үр тариа 1636.8 тн-оор бага, төмс 143.8 тн-оор, хүнсний ногоо 294.6 тн-оор тус тус их байна. Иргэд 29202.1 тн хадлан, 5529.7 тн гар тэжээл бэлтгэжээ.

Хөрөнгө оруулалт, Барилга

Энэ онд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд 11.6 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 5.4 тэрбум буюу 47.1 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 582.2 сая. төгрөг буюу 5.0 хувь нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 2.0 тэр бум төгрөг буюу 17.3 хувь нь гадаадын хөрөнгөөр, 3.1 тэр бум төгрөг буюу 26.9 хувь нь иргэний өөрийн хөрөнгөөр хийгдсэн байна.

Энэ онд тус аймагт 4.1 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 95 объектод хийж гүйцэтгэснээс Улс, яамдын хөрөнгөөр 41 объектод 2291.6 сая, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 33 объектод 943.7 сая. төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэжээ. Эдгээрийн 91.4 хувь нь их засварын ажил байна.

Нийт гүйцэтгэсэн ажлын 22.7 хувь буюу 933.8 сая.төгрөгийн ажлыг аймгийн барилгын чиглэлийн аж ахуйн нэгжүүд гүйцэтгэжээ.

Тээвэр, холбоо

Аймгийн дүнгээр 430 иргэн тээврийн үйлчилгээ явуулж 20.1 мян.тн ачаа тээвэрлэн, 8.4 мян. тн/км-ийн ачаа эргэлт, 149.6 мян. зорчигч тээвэрлэн, 38.0 мян хүн/ км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэж 688.3 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх оноос тээврийн орлого 22.9 хувиар өсчээ.

Холбооны байгууллагууд 534.3 сая.төгрөгийн тарифын орлоготой ажилласны 51.0 хувийг хүн амын орлого эзэлж, өнгөрсөн оноос тарифын орлогын дүн 15.8 хувиар буурчээ.Аймгийн 1800 айл өрх, 498 аж ахуйн нэгж байгууллага телефон цэгтэй байгаа ба 4500 телевизийн цэг, 370 кабелийн цэг ашиглагдаж байна. Үүрэн телефон хэрэглэгчийн тоо 24830 болсон байна. Өнгөрсөн оноос телефон цэгийн тоо 12.6 хувиар буурч, телевизийн цэгийн тоо 8.4 хувиар, үүрэн телефон хэрэглэгчийн тоо 65.9 хувиар өсчээ. Интернетээр үйлчлүүлэгчдийн тоо 2350-д хүрч өмнөх оноос 3.9 дахин өсч интернетийн үйлчилгээнээс 14.4 сая.төгрөг орсон нь өмнөх оныхоос 21.4 хувиар нэмэгдсэн байна.

Шуудан холбооны орлого 87.3 сая төгрөг болж өнгөрсөн оноос 22.8 хувиар үүнээс бичиг захидал 7.1 хувиар , тогтмол хэвлэлийн захиалга 7.5 хувиар буурсан байна.

Худалдаа, үйлчилгээ

Аймгийн худалдаа нийтийн хоолны 1099 цэг салбарууд 4.4 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оноос 12.5 хувиар өсчээ. Худалдаа нийтийн хоолны цэгийн тоо өмнөх оноос 87 -оор нэмэгджээ.

Орон сууц

Энэ онд иргэдийн өөрийн хөрөнгөөр 16948 м.кв ашигтай талбай бүхий 281 хувийн өмчийн орон сууц ашиглалтанд оржээ. Эдгээр сууцанд 299 өрх буюу 1582 хүн оршин сууж, амьдарч байна.

Үүнд: Сумдын иргэдийн амины зориулалтаар барьсан хувийн, энгийн галлагаатай байшингууд хамрагдсан болно. Харин төвлөрсөн системд холбогдсон болон төрийн өмчийн орон сууц ашиглалтанд ороогүй.

Бусад мэдээлэл.

Аймгийн татварын албанд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 811 байгаагийн төсөвт байгууллага -191, ХК 20, ХХК -288, салбарууд-83, хоршоо-86, ЗБН,ББН-83, төрийн бус байгууллага-21, ОНБайгууллага-14,хадгаламж зээлийн хоршоо -13,шашны байгууллага-6 байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

